

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ <sup>1</sup> 16 (ТОЙМ)

Хуралдаан 2009 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 14.30 цагт эхэлж, 16.10 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 1 цаг 40 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	"Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах шинэчлэн боловсруулсан журам"-ын төслийн тухай*	"Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын төсөлд дахин редакци хийгээд Улсын Их Хуралд хүргүүлэхээр тогтов.
2	"Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам" батлах тухай	1."Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын төсөлд дахин редакци хийгээд батлах. 2."Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
3	Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хуулийн хэлтсийн даргаар ажиллаж байсан Н.Ганбаатарын гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	1."Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай" Засаг даргын Тамгын газрын даргын 2008 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 95 дугаар тушаалын "Нэг" дэх заалтаас аймгийн Хууль зүйн хэлтсийн дарга Н.Ганбаатарт холбогдох хэсгийг хүчингүй болгох. 2.Дээрх тушаалын холбогдох хэсгийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авч, гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу Н.Ганбаатарыг тодорхой албан тушаалд томилж ажиллуулахыг Завхан аймгийн Засаг даргын Тамгын газарт зөвлөмж болгох.
4	Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны референтээр ажиллаж байсан Г.Чагнаадоржийн гаргасан гомдлын талаар Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай	Хойшлуулав.
5	Зарим агентлагийн төрийн албан хаагчдаас төрийн албаны мэргэшлийн шалгалт авсан дүнгийн тухай	1.Төрийн захирааны төв байгууллагын төрийн албаны мэргэшлийн шалгалтын салбар комиссоос 2009 оны 6 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Авто тээврийн газрын 9 ажилтныг 1 дүгээр хавсралтаар, Авто замын газрын 7 ажилтныг 2 дугаар хавсралтаар, Цөмийн энергийн газрын 10 ажилтныг 3 дугаар хавсралтаар, Эрчим хүчний газрын 12 ажилтныг 4 дүгээр хавсралтаар, Мал эмнэлэг, үржлийн газрын 1 ажилтныг 5 дугаар хавсралтаар, Ойн газрын 2 ажилтныг 6 дугаар хавсралтаар,

		<p>Стандартчилал, хэмжил зүйн газрын 5 ажилтныг 7 дугаар хавсралтаар тус тус төрийн жинхэнэ албаны нөөцийн бүртгэлд бүртгэх.</p> <p>2.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийг тухайн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэн томилох эрх бүхий албан тушаалтанд нь хүргүүлэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газрын дэд даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан дүнгийн тухай</p>	<p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газрын орлогч даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны албан тушаалд Төрийн албаны тухай хуулийн 17.4, 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 33 дугаар зүйлийг тус тус баримталж, дээр дурдсан албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадварын хувьд хангаж байгаа Р.Ононг нэр дэвшүүлж, томилох эрх бүхий этгээдэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	<p>Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар багийн иргэн Ж.Наранболдын гаргасан гомдлыг шалгасан Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай</p>	<p>1.Дорноговь аймгийн Засаг даргын 2009 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 45 дугаар захирамжийн “...аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газрын даргаар Л.Шархүүхэнийг томилсугай гэсэн 2 дахь заалтыг хүчингүй болгож, Ж.Наранболдыг уг албан тушаалд 2009 оны 7 дугаар сарын 20-ны дотор томилохыг Засаг дарга П.Ганхуягт үүрэг болгох.</p> <p>2.Л.Шархүүхэнийг Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газрын даргаар (2009 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс) томилсны улмаас төрд учирсан хохирлыг тооцож, Төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба (Ц.Самбаллхүндэв)-нд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
8	<p>Ашигт малтмалын газрын дотоод хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшигч иргэн С.Дашдаржаагийн гаргасан гомдлыг шалгасан Маргаан хянан шалгах комиссын шийдвэрийн тухай</p>	<p>1.Ашигт малтмалын газрын даргын 2009 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 62 дугаар тушаалыг хүчингүй болгох.</p> <p>2.”Ашигт малтмалын газрын дотоод хяналт хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшигч иргэн С.Дашдаржааг 2009 оны 7 дугаар сарын 20-ны дотор томилохыг Ашигт малтмалын газрын даргад үүрэг болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.</p>
9	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх асан Н.Лхагвааг төрийн албаны нөөцөд бүртгэх тухай</p>	<p>1.2001-2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нийгмийн бодлогын зөвлөхөөр томилогдон ажилласан Лувсаннъямын Лхагвааг төрийн жинхэнэ</p>

		албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
10	Бусад асуудал: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээлэл, технологийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтанд дүгнэлт гаргах тухай	1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээлэл, технологийн хэлтсийн даргын албан тушаалд Төрийн албаны тухай хуулийн 17.1, 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 33 дугаар зүйлийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас дээр дурдсан албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг мэдлэг, боловсрол, мэргэжил, туршлага, мэргэшлийн ур чадварын хувьд хангаж байгаа Даваадоржийн Одбаярыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээлэл, технологийн хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ш.Солонгод санал болгох тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гаргахаар тогтов.

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ